

# СҮРЬЕЭГҮЙ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

---

СЭТГҮҮЛЧИД БОЛОН ИРГЭД БИЧИЖ БАЙНА

---

*Бэлтгэсэн:* Д.Доржмаа  
Б.Оюунцэцэг  
Б.Должинсүрэн  
Б.Дарийма  
П.Янжиндулам

## ӨМНӨТГӨЛ ҮГ

Сүрьеэтэй тэмцэх ажилд иргэдийн эрүүл мэндийн боловсрол тэр дундаа сүрьеэ өвчний талаар үнэн зөв мэдлэгтэй байх явдал юм. Олон нийтийг ухааруулан, сэнхрүүлэх ажилд манай сэтгүүлчдийн хувь нэмэр их чухал учраас 2011 оны ”Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр“-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа” шилдэг бичлэгийн уралдаанд оролцож мэргэжилтнүүдийн зүгээс өндөр үнэлэлт авсан бүтээлүүдээс түүвэрлэн авсан нийтлэлүүд болон сүрьеэ өвчнөөр өвчлилсөн ч эдгэрэх хүсэл эрмэлзэл, хичээл зүтгэл дүүрэн иргэдийн бүтээлүүдээс уншигч таньд өргөн барьж байгаадаа таатай байна.

Хүн амд сүрьеэ өвчний тухай үнэн зөв мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, сүрьеэгээс урьдчилан сэргийлэх арга зам, эмчилгээг таслахгүй бүрэн гүйцэд хийлгэхийн ач холбогдол болон төр засаг, олон нийт, иргэний нийгмийн байгууллага, хувь хүний үүрэг оролцооны талаар тодорхой санал дэвшүүлсэн нийтлэл бичсэн эрхэм сэтгүүлч нар, хүнд хэцүү өвчнөө даван туулах урам зоригоор бусдаа үлгэрлэн амжилттай эмчлэгдэж сэтгэгдлээ хуваалцсан үйлчлүүлэгч та бүхэндээ талархалаа илэрхийлье. Та бүхний туулсан амьдрал, асуудал дэвшүүлсэн нийтлэлүүд тань олон сүрьеэтэй өвчтөнийг эмчлэн эдгэрэх урам зориг өгнөө гэдэгт итгэлтэй байна.

Зарим мэдээлэл буруу ташаа байхыг үгүйсгэх аргагүй боловч бидний дунд бас л ийм буруу ойлголт байсаар байгааг давхар харуулж байгаа учир энэхүү нийтлэлийн түүвэр сэтгүүлчдэд сайн гарын авлага болж “мэргэжсэн” сэтгүүлзүй хөгжихөд нэмэр болох болов уу.

*Н. Наранбат  
Анагаах ухааны доктор*

**Гарчиг**

1. Жил гаруй болсон ч сүрьеэ өвчин эдгээнд нь би үргэлж баярладаг. Б.Болорчимэг
2. Цагаан тахалыг нуувчнаас гаргая. У.Бадамцэцэг
3. **БИ СҮРЬЕЭГҮЙ БОЛСОН ШҮҮ ДЭЭ.** Ж.Мөнх-Очир
4. Танихгүй нян ирээдүйд аялсан нь. Ч.Болортуяа
5. Шинэлэгээр сэтгэж сүрьеэтэй тэмцье. Б.Батзаяа
6. Ялалт бидний гарт. Б.Ариунтунгалаг
7. Сэтгэлийн үг. Д.Энхчимэг
8. Ялалт бидний гарт Д.Болор-Эрдэнэ
9. Шинээр сэтгэж сүрьеэтэй тэмцье. П.Золзаяа
10. Сүрьеэ өвчинтэй тэмцэх өдөрт зориулав. Б.Мөнхбат

## **СЭТГҮҮЛЧ, НИЙТЛЭГЧ НАРЫН БҮТЭЭЛ:**

**Жил гаруй болсон ч сүрьеэ өвчин эдгэсэнд нь  
би үргэлж баярладаг**

*Б.Болорчимэг  
Сонины нэр*

Би үнэхээр их баярладаг юм. Одоогоос арваад жилийн өмнө дөө, ганц эгч маань онош нь тодорхойгүй нэг өвчнөөр өвчилж бараг жил гаруй болсон юм. Үргэлж ханиалгаж бас турж эцэж байгааг харах надад үнэхээр хэцүү байлаа. Цэргийн хүн болохоор тэр шугамаараа бид бүхний нэрлэж заншсан госпиталийн эмнэлэгт үзүүлэх хэдий ч нэг л сайжралыг олохгүй байв. Гурван ч удаа дотрын тасагт хэвтэн эмчлүүлсэн ч үр дүн гарсангүй. Орой ажлаасаа тарж ирээд цаашаа харан ороо засах эгчийнхээ турсаныг хараад үнэхээр их өрөвдөж түүнийг унтсан хойно чимээгүйхэн орондоо уйлж хэвтсэн юм. Тийн уйлж хэвтэх үедээ шууд л эрхлэгчид хэлье гэж бодлоо. Тэр үед манай сонины эрхлэгчээр одоо Монголын Үндэсний музейн захирал, Соёлын гавьяат зүтгэлтэн Ж.Саруулбуян ажиллаж байлаа. Ийнхүү бодсон нь бас учиртай юм. 2002 онд манай сонины редакцид дандаа шижигнэсэн залуу сэтгүүлч нар байсан болохоор бид бүхний сэтгүүлч болох гарааг нь зөв тавих бас юм үзэж нүд тайлуулах гэж Саруул эрхлэгч гадаад дотоод руу явахдаа нэг хоёроор нь дагуулж явдаг байлаа. Нэг удаа Төв аймгийн Мөнгөнморьт руу явахад нь миний ээлж таарч сурвалжлагаар хамт явсан юм. Монгол Улсын гавьяат жүжигчин н.Чулуунцэцэг, Соёлын гавьяат зүтгэлтэн Ч.Дагвадорж гээд урлаг соёлын томчуудын хамтаар явав. Энд тэндхийн сонин хачныг хүүрнэх тэднийг яриаг сонсч байх тэр үед Саруул эрхлэгчийн багын найз нэгэн эмч Улсын Клиникийн нэгдүгээр эмнэлэгт ажилладаг, мэргэжилдээ чамгүй нэгэн гэж сонссон учир эрхлэгчид хэлэхээр шийдсэн хэрэг. Өглөөний шуурхайн дараа Саруул эрхлэгчид шууд л зовлонгоо тоочиж гарлаа. Миний яриаг чимээгүй сонсож суусан эрхлэгч “Манай найз дээр одоо аваад очъё” гэлээ. Гэхдээ эгчтэй энэ талаар огт ярилцаагүй болохоор тэр дороо хариу хэлж чадалгүй эгчтэйгээ холбоо бариад эрхлэгчид эргэж хэлэхээр тохирлоо. Эрхлэгчийн өрөөнөөс сэтгэл өөдрөг гарсан би шууд л эгчрүүгээ утас цохиж

учрыг хэлтэл “Өө тэгье тэгье” хэмээлээ. Арга ч үгүй биз дээ, хөөрхий. Жил гаруй онош нь тодрохгүй байсан болохоор дуртай зөвшөөрч маргааш өглөө 09.00 цагт Клиникийн нэгдүгээр эмнэлэг дээр эрхлэгчтэй гурвуулаа уулзаж, түүний найз Д.Цогт эмчид үзүүлэхээр өрөө рүү нь ортол тэрбээр эгчийг минь харангуугаа шууд л “Өө ойлгомжтой л юм байна даа” гэснээ “За юу ч гэсэн зүүн гараа дээш нь өргө дөө” гэлээ. Жаахан харснаа “За за сүрьеэ туссан байна” гэв. Энэ үгийг сонссон эгч маань шууд л “Би шинжилгээ өгсөн шүү дээ. Сүрьеэ тусаагүй байна гэсэн” хэмээн ихэд айсан, эмээсэн өнгөөр хэлтэл Д.Цогт эмч “Би олон жил энэ өвчнөөр дагнасан эмч хүн. Чи сүрьеэгийн шинжилгээ дахиж өг. Гэхдээ ХӨСҮТ-д очиж өг” гэсэн товч бөгөөд тодорхой хариултыг өглөө. Жил гаруй эмчилгээ хийлгэж байгаа ч нэг ч эмч түүнийг “сүрьеэ өвчин тусчээ” гэж хэлээгүй болохоор үл итгэсэн нь тэр юм. Гэхдээ Д.Цогт эмчийн хэлж байгаад итгэхгүй байх аргагүй байсан учир тэндээсээ гараад шууд л ХӨСҮТ-д очиж шинжилгээ өгтөл “хариу нь харин дээрх өвчин тусчээ. Тусах тусахдаа нэлээд хүнд туссан байна шууд эмнэлэгт хэвт” гэсэн юм.

### ЦАГ АЛДАЛГҮЙ ЭРЧИМТЭЙ ЭМЧИЛГЭЭ ХИЙЛГЭХ НЬ ӨВЧИН ТҮРГЭН ЭДГЭХ ГАРЦ БОЛДОГ

Тэр даруй эмчилгээг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн клиникт хийж эгч хоёр сар гаруй хугацаанд эмнэлэгт хэвтлээ. Гэхдээ эгчийг эмчлэхээс гадна нэг гэр бүлд байдаг бүх хүнээс шинжилгээ авна хэмээж дүү бид хоёроос шинжилгээ авав. Хариу нь харин “Халдвар аваагүй” гэж гарлаа. Хоёр сар гаруйн хугацаанд эмнэлэгт хэвтсэн эгч маань үнэхээр сайн эмчлэгдэж гарч ирсэн юм. Эмчилгээ нь тун сайн хийгддэг юм билээ. Эмнэлгээс гарч ирсэнийх нь дараа дөрвөн сар нэгэн эмэгтэй манай гэрээр ирж, эгчид эм өгдөг байлаа. Тэрбээр эмээ харж байгаад уулгаад явна. Нэрийг нь сайн санахгүй байгаа хэдий ч эм өгөхөөр ирдэг тэр эгч үнэхээр хариуцлагатай нэгэн байсан юм. Эгч ажлаасаа ирээгүй үед эмийг нь аваад үлдэх гэхээр “Хүүе болохгүй” хэмээн сандарч “дахин ирье” хэмээн буцна. Зарим үед тэр эгч манайд өдөр дөрөв ирэх тохиолдол ч гарч байсан. Тэрхүү эмийг эгчид дөрвөн сар тун хариуцлагатай уулгасан. дөрвөн сарын дараа эгч ХӨСҮТ-д очиж шинжилгээ өгтөл цоо эрүүл болжээ хэмээсэн юм. Гурван жил хүүхэд гаргаж болохгүй, бас ханиад хүрвэл

нуруундаа гич наалгаж болохгүй энэ тэр гээд олон мөрдөх ёстой “дүрэм, журам” байдаг юм билээ. Эгч маань энэ бүгдийг нэг бүрчлэн мөрдөж үнэхээр цоо эрүүл болсон юм. Одоо эгч маань эрүүл саруул, элдэв өвчингүй, хань ижил, үр хүүхэдтэйгээ халуун бүлээрээ сайхан амьдарч байгаа. Гэхдээ манай гэр бүлийнхэн эгчийгээ эрүүл саруул болсны дараа сүрьеэ өвчний талаар тун сайн мэдлэгтэй болж хүн бүхэнд ханиад хүрвэл хурдан эдгээх хэрэгтэй, бас сүрьеэ өвчин тусвал турж эцэж хөлрөх нь эхний шинж тэмдэг гээд энэ талын мэдээллийг ойр байдаг хүмүүстээ байнга хэлдэг болсон гэх үү дээ. Хамгийн гол нь эмчилгээ хийлгэж гарсаныхаа дараа эмчийн хэлснийг тун сайн мөрдлөг болгохоос гадна эмээ яг тогтсон хугацаанд нь ууна гэдэг хамгийн чухал юм билээ. Түүнээс гадна сүрьеэ өвчин туссан бол эмчид шууд хандан үзүүлж, яаралтай эмчлүүлвэл эмчилгээ тун сайн авч ор мөргүй эдгэдэг гэдгийг иргэд маань ойлгоосой. Сүрьеэ эдгэрдэг өвчин шүү.

### **Хаана нийтлэгдсэн мэдээлэл Цагаан тахлыг нуувчнаас гаргаж**

*У.Бадамцэцэг  
“Ардчилал” үндэсний өдөр тутмын сонин*

20 зууны эхний хагаст нас баралтын гол шалтгаан нь цагаан тахал гэж нэрлэгдэж байсан сүрьеэ өвчин байжээ. Тухайн үед энэ өвчний талаархи мэдлэг тааруу, эм тариа ч бага байсан болохоор яалтай ч билээ. Харин энэхүү өвчнийг эмчлэх эм хангалттай, цаашлаад эмчилгээг нь үнэ төлбөргүй хийж байгаа энэ сайхан цаг үед яагаад хүмүүс сүрьеэ өвчнөөр амиа алдсаар байгаа юм бол. Энэ хэний буруу вэ. 2010 оны байдлаар Монгол Улсын хүн амын дундах халдварт өвчний өвчлөлийн байдалд хийсэн судалгаагаар 100 мянган хүн ам тутамд тэргүүлэх байр эзэлж байгаа таван өвчнийг нэрлэжээ. Вируст гепатит 9099 гэсэн тоогоороо нэгд орсон бол заг хүйтэн 5741, трихомониаз 4623, мөөгөнцөр 4425, сүрьеэ 4213 гэсэн үзүүлэлтээр айргийн тавд багтжээ. Харин нас баралтын хувьд 153 гэсэн тоогоор сүрьеэ тэргүүлж, вируст гепатит 24, нярайн халдвар зургаа, менингококкт халдвар дөрөв, тэмбүүгээр гурван нас баралт бүртгэгджээ.

***Сүрьеэтэй гэдгээ нуухаа больцгооё***

Үнэнийг хэлэхэд сүрьеэ өвчин гэхээр сайн мэдэхгүй байж сэжиглэж явсан үе надад бий. Учир нь, өнгөрсөн жил нэг танил маань нэг өдөр “Таньдаг өрхийн эмнэлэг, эмч байна уу. Найз нь сүрьеэгээр өвдчихөж. Чи битгий хүнд хэлээрэй. Өрхийн эмнэлэгтээ хандаад эм үнэгүй авч, эмчилгээ хийлгэдэг юм байна” гэв. Үнэ төлбөргүй юм бол яагаад амьдарч байгаа газрынхаа өрхийн эмнэлэгт хандаж болохгүй байгаа талаар лавлахад “Айлын хажуу өрөөнд амьдардаг болохоор гэрийн эздэд мэдэгдэж болохгүй байна. Хамт амьдарч байгаа хүмүүсийг халдвар авсан байж болзошгүй гээд сүрьеэгийн шинжилгээнд хамруулдаг гэнэ. Намайг байрнаасаа хөөх байлгүй” гэв. Надад таньдаг эмнэлэг ч гэж юу байхав. Гэхдээ сүрьеэтэй гэхээр нь тухайн үед сэжиглээд уулзахгүй гэж бодоод л амжсан. Хэсэг хугацаанд найз маань холбоо барихгүй алга болчихов. Харин гэнэтхэн нэг өдөр “Нутагтаа ирээд хоёр сар болж байна. Нээрээ сүрьеэ биш байсан байна билээ” гэж утсаар ярьсан юм. Гэнэтхэн турж, маш их ханиалгадаг охин байсан болохоор өвдсөн гэдэг нь мэдээж үнэн л байсан байх. Ингээд харахаар хүн болгон сүрьеэтэй гэдгээ нууж байгаа нь ойлгомжтой. Өрөө хөлслүүлдэг айлынх нь хүмүүс, магадгүй найз нөхөд, ажлын хамт олон нь сүрьеэгийн халдвар аваагүй гэх баталгаа огт байхгүй. Яагаад гэхээр сүрьеэ өвчний нян агаар дуслын замаар халдварладаг болохоор хаа сайгүй байгаа. Халдвар тархах эгзэг гэр бүлийн хүрээнд 100 хувь, найзуудын хувьд 10 хувь, харин найзыг минь танихгүй та буюу гадны хүмүүст нэг хувь байдаг байна. Дэлхий даяар гурван хүн тутмын нэг нь, Монголд 100 мянган хүн тутамд дахь өвчлөлийн тоогоор айргийн тавд багтаад байхад сүрьеэгээр өвдсөн нэг ч хүнийг би мэдэхгүй, танихгүй. Хэн ч гэсэн энэ өвчнөөр өвчилж мэдэх учраас сүрьеэгээс ичихээ больцгооё, нуухгүй явцгаая. Сүрьеэ өвчтэй хүн бүр өөрөө өөрийгөө нуувчинд хийж, найз нөхөд, ажлын хамт олондоо худлаа ярьж яваа нь энэхүү өвчнийг даамжруулж байна. Найз сүрьеэгээр өвдчихөж, гэхдээ 100 хувь эдгэдэг юм байна. Миний найз, ажлын хамт олон минь халдвар авсан байх вий, шинжилгээнд хамрагдаарай гээд хэлчих зоригтой байцгаая. Харин та нар өвдсөн нэгнийгээ сэтгэлээр дэмжиж гадуурхахгүй байя.

***Төгс эдгэдэг өвчнийг 30 хувь болгох хэрэг байна уу***

Сүрьеэгийн нянг бүрэн устгах эмчилгээ хийлгэхэд дор хаяж зургаахан сар шаардагддаг. Эмчилгээ эхлээд хэдхэн долоо



хоногийн дараагаас зовиур арилчихдаг. Гэтэл эмээ тогтмол уухгүй хэнэггүй зангаас болж сүрьеэгийн нян дахин идэвхждэг байна. Ингэснээр удаан хугацаагаар өвчлөх, олон эмэнд дасалтай сүрьеэ болох аюулд хүрдэг. Олон эмэнд дасал болсон сүрьеэг дарахын тулд гаж нөлөө ихтэй өөр шинэ эмүүдийг удаан хугацаагаар ууж, таны өвчин сэдэрч найз нөхөд, гэр бүлийнхэндээ халдвар тараах эрсдэл илүү өндөр болдгийг судалгаа харуулжээ. Олон эмэнд дасал болсон сүрьеэгээр эмчлүүлж байгаа 155 хүнийг судалгаанд хамруулахад 78.7 хувь нь нийслэл, 11.6 хувь хөдөө орон нутгийнх, 9.7 хувийг хоригдлууд эзэлжээ. /2008 оны тоо баримт/ Үүнээс гурван ганц бие, 111 нь 2-5 ам бүлтэй, 22 нь 6-8 ам бүлтэй, гурав нь есөөс дээш ам бүлтэй байжээ. Гэтэл дээрх хүмүүсийн гэр бүлийн гишүүдээс 18 нь олон эмэнд дасалтай сүрьеэгээр, 15 хүн дасалгүй хэлбэрийнхээр өвчилжээ. 155 хүнийг эмчилгээ хийснээс хойш 18-24 сарын дараахь үр дүнг 35 хүнд тооцоход 22 нь эдгэрч, хоёр нь эмчилгээ тасалж, таван хүн нас барж, зургаа нь үр дүнгүй эмчлэгджээ. Өөрөөр хэлбэл, олон эмэнд дасалтай сүрьеэ эдгэрэх магадлал ердөө л 30 хувь. Мөн тантай хамт байгаа үр хүүхэд, найз нөхөд эмэнд дасалтай сүрьеэгээр шууд л өвчилнө. Төгс эдгэдэг өвчнийг хэнэггүй зангаасаа болж ингэж 30 хувь болгох хэрэг байна уу. Өвчнөө даамжруулахгүй байх тал дээр өөрсдөө анхаарал тавья.

### ***Сүрьеэг номхотгосон Хятадын гайхамшиг***

Дэлхийд энэхүү өвчнөөр Энэтхэг улс толгой цохиж, өмнөд хөрш аман хүзүүддэг. Сүрьеэ өвчинтэй хүн дөрвөн сая 500 мянга гаруй болсноор, нийт хүн амын 0.34 хувийг эзэлжээ. Жил бүр 130 мянга гаруй хүн энэхүү өвчнөөр алтан амиа алдаж, бусад халдварт өвчнөөр нас барсан нийт хүний тоотой тэнцдэг болжээ. Иймээс Хятад улс сүрьеэ өвчинд анхаарлаа хандуулж маш дорвитой арга хэмжээ авснаар зохих хэмжээнд хяналтдаа авч чаджээ. Сүрьеэ өвчнийг дарах хамгийн анхны алхмаа халдвар авсан хүнийг илрүүлэх тал дээр анхаарч ажиллажээ. Үүний тулд Хятад улс сүрьеэ өвчнийг илрүүлэх тоног төхөөрөмж байрлуулах, тусгай мэргэжлийн мэргэжилтэн бэлтгэх, суртал ухуулга хийх зэрэг олон арга хэмжээ авчээ. 2004 оны нэгдүгээр сард Хятад улс бүх улсын хэмжээнд халдварт өвчнөөс сэргийлэх, мэдүүлэх систем байгуулсан байна. Үүний үр дүнд 2003 онд Хятадад сүрьеэ өвчнийг илрүүлсэн хэмжээ 39 хувьд хүрч байсан бол, 2005 онд 79 хувьд хүрч чаджээ. Мөн үнэ төлбөргүй эмчилгээнд зориулан Хятадын төв санхүү жил бүр 40 сая юаний хөрөнгө оруулж, 2004 онд 300 сая юань орчим болгон нэмэгдүүлж, 2005 онд Хятад

## **СҮРЬЕЭГҮЙ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА**

---

улс сүрьеэ өвчний мэдээллийн систем ажиллуулж, өвчтөний талаархи мэдээллийн бааз байгуулжээ. Ингээд 2005 оны эцэс болоход Хятад улс сүрьеэ өвчний эсрэг авсан арга хэмжээндээ ДЭМБ-аас 91 хувь гэсэн үнэлгээ авчээ. Үүнээс жишээ авбал яагаад болохгүй гэж.

*Хаана нийтлэгдсэн*

### **БИ СҮРЬЕЭГҮЙ БОЛСОН ШҮҮ ДЭЭ**

*Ж.Мөнх-Очир  
Сонины нэр*

#### *Сүрьеэ эдгэрдэг өвчин*

-За уушиг гайгүй юу? Ингэж нөхөр маань асуув. Уур хүрэх шахлаа. Насаараа сүрьеэтэй хатах юм гэж санаа юу хэмээн үг өдмөөр бодогдож байна. Сүрьеэ эдгэрдэг өвчин. Би сүрьеэгүй болсон шүү дээ. Ингэж нөхөртөө хэлэв.

#### *Өвдсөн минь*

Дээд сургууль төгсөх хавар. Сургууль руу орж явтал толгой эргэх нь тэр. Хавар ирсэн болоод тэр үү, бие нозоороод л. Ерөөсөө сульдаж ядраад байдаг болов. Улсын шалгалт, дипломын ажил гээд ачаалал ихэджээ. Шөнө дутуу унтаад байгаа биз. Хоол сайн ид. Хүмүүс ингэж онош тавьж байна. Үеийн нэг нөхөртэйгөө галладаг байранд байх. Номын санд сууж сууж ирэхэд хүйтэн гэж чичрүүлэх шахна. Нэгэнт шөнө дөл болсон болохоор юун гал түлэх, хоол хийх. Хүйтэн хөнжилд орж эвхрэн хэвтэнэ. Даарсандаа болоо биз, ханиалгана. Өдөр хоног иймэрхүү үргэлжилсээр сургуулиа төгсч хангайн хүү говийн “хүргэн” болохоор галт тэргэнд суув. Зүүнбаянгийн сургуульд багшлах тэр намар ямар их ханиалгасан гээч. Шар шар цэр гарах. Орой болохоор бие арзайна. Даараад ч байх шиг. Тэгсэн хэрнээ шөнө дэвсгэр, хөнжлөө чийг даатал хөлөрчихнө. Хучлага зузаадаж хэмээн нимгэлнэ. Угийн хорчгор амьтан их ханиалгасандаа тамир алддаг юм уу, биеийн жин ч буурах маягтай. Ээ, их ханиалгах хэцүү. Хөлс дааварлаад, цээжээр өвдөх шиг болно. Аптекаас авсан эмийг хармайнаас салгахгүй. Уугаад ч нөлөө бага. Эмчид үзүүлсэн чинь хэвт гэж байна. Авах цалин яахав. Ганц бие хүнд мөнгөний хэрэгцээ асуудал биш. Дөрөв төгсөөд сумдаас ирж арайхийн хамт олон бүрдэж эхэлсэн ангийнхнаасаа

холдох аргагүй. Бусад ангид орох цагийн хичээл ч тасарна. Энэ мэтээр шалтаглан явж байтал ханиах халуурах явдал газар авч цустай цэр ч гарах янзтай. Ажил яахав, биеэ бод гэж Болд эмч загнах байдалтай шүү. Арга буюу хэвтлээ. Дуу алдан ёолоод байх өвчингүй болохоор удахгүй биз гэж бодон хоног тоолсоор. Арав хоног. Хагас сар . . . !!! Багш нар эргээд л, ангийн охид, банди нар бууз, шөл зөөгөөд л. Би эмийг янз янзаар ууна. Хонгондоо тариа шахуулсаар хөндүүр болчихлоо. Нэг мэдсэн 2 сар болжээ. За эмч минь, гарья.

### *Эмчлүүлсэн минь*

Хичээл тарж Булганаа зорив. Нутгийн агаарт ирээд сайхан унтаж амарна гэсэн чинь нэг л биш. Ханиах, халуурах, цээжээр хөндүүрлэх, цэр бөөн бөөнөөр гарах, хэвтэрт хөлрөх маань засардаггүй шүү. Хол байж байгаад ирсэн хэмээн сайхан хоолоор дайлуулах нь аятайхан санагдавч тийм ч дуртай биш. Эмчид үзүүл гээд эгч үглэх болов. Наадам өнгөрөөд эмнэлэгт очлоо. “Манту” тавиул. Цэрээ шинжлүүл. Цээжний зураг авахуул. Бүгдийг гүйцэтгэв. Цэрмаа эмч дуудаад, уушиг чинь хоёулаа харлачихжээ. Яаралтай хэвт гэв. Паскнаас эхлээд эмийг ч ууж гарлаа. Давхарлаад шүү. Тариа ч завсарлагагүй. Аав минь уушигны өвчнөөр өөд болсон гэдэг. Би бас энэ. Удамшдаг монди байх нь л дээ? Тэр үед паск нунтаг байсан санагдана. Уушиг муу гээд бүгшүүлж ханиалгасан хүмүүс их бий дээ. Зарим нь бараг насаараа тэгж яваа болов уу гэж санадаг. Сүрьеэ бол халдарт өвчин. Бүр нийгмийн халдварт шүү. Ингэж хэвлэл номонд бичсэнийг уншлаа. Очиж очиж ийм өвчин тусах гэж. Уулзсан зарим нөхөд дөлөөд хол хөндийхөн ч зогсох маягтай. Арга ч үгүй. Би халдвар тээж яваа л даа.

Олон эм уухаас зүрхшээдэг юм уу, зарим хүн дэрэн дороо хадгалж байгаад хогийн саванд хийж харагдана. Би ч хааяа дуурайна. Нэг удаа жижүүрийн сувилагч С.Бямбажав гуайд баригдлаа. Эмч ч дуулчихжээ. Юра эмч өглөөний үзлэг хийж нэлээд чагнаж үзсэнээ, одоохондоо янзандаа байна. Жаахан байж байгаад эмчилгээ авна даа. Дэрэн доор чинь эм байна гэл үү? Мартчихсан юм уу? Эм тариагаа тасалж болохгүй шүү. Эмээ уугаад л байхаар эдгэрнэ. Зүв зүгээр болно гэв. Дөлгөөхөн, намуухан, бас зөвлөсөн тэр үг надад урам өглөө. Эмээ бүрэн хэрэглээд байвал нээрэн хоёр уушиг минь эдгэчихнэ гэсэн итгэл төрөв. Багшийн даалгавар биелүүлж байгаа сурагч адил “истор”-т эмчийн бичсэн эмийг илүү юу гэхээс дутаалгүй уудаг боллоо. “Эм тариагаа тасалж болохгүй шүү. Тэгээд л байхаар эдгэрнэ.

Зүв зүгээр болно”. Эмчийн энэ үг чихэнд хоногшиж сэтгэлд шингэжээ.

### *Эдгэрсэн минь*



Ханиах маань зогслоо. Халуурахаа аль эрт больсон. Шөнө хөлрөхгүй. Ядарч сульдах ч гайгүй шүү. Надад бол эдгэрчихсэн л юм шиг санагдана. Үе үе Жамбал гуай дуудаж, эмч чиний цээжний зургийг ав гэсэн гэнэ. Хааяа Цэрмаа, Юра эмчийн хэн нэг нь рентгенээр харна. Айраг идээтэй найман сарыг эмнэлэгт л өнгөрөөв. За гар даа гэх болов уу

хэмээн горьдоно. Ер үгүй шүү. Эм тариа үргэлжилнэ. Өдөр хоног ээлжилсээр. Ес, арван сар өнгөрлөө. Сүрьеэгийн диспансерийн бага эмч Д.Мишигдорж бид хоёр ний нуугүй ярина.

-Өө хөөрхий, манай хяналтад байдаг Дамбий гуай өөд болсон гэнэ.

-Сүрьеэгээр үү? Эдгэсэнгүй еэ?

-Тэгэхээс яахав. Эмээ уудаггүй, хяналтын үе шатны эмчилгээг ирж авдаггүй хүн байхгүй юу.

-Энэ хоёрдугаар палатны Давааням гуай бараг жил болгон ирж хэвтдэг гээд л ярьж байна лээ.

-Архагшуулчихсан юм. Олигтойхон эмчлүүлэхгүй бол их уддаг өвчин дөө.

Нэг удаа ингэж хөөрөлдөв. Эмээ сайн уухгүй бол салдаггүй, нас ч бардаг өвчин юм байна даа гэх айдас төрж эмнэлгээс гарах гэж яарахыг больж билээ. Энгийн ийм яриа ч гэсэн ухуулга болдог юм байна лээ. Бүүр 12 дугаар сар дундаа орчихов. Тоолж үзсэн чинь бараг хагас жил болжээ. Халуун зунаар хэвтсэн би ес эхэлж хүйтэн тачигнах гэж байхад эмнэлгээс гарав. Боодол зүйлтэй харьсан. 2 сар уух эм маань тэр. Ажил хийж болохгүй гэнэ ээ. Группэд орлоо. Говийн “хүргэн” болно гэсэн маань ч талаар болж “гологдлоо”. Ямар ч гэсэн нутагтаа шилжин ирэв. За эмээ л таслахгүй ууна гээд “Изониазид”-аа хармайнаас салгахгүй авч явна. Тэгэхгүй бол мартчихна шүү дээ.

Группийн хугацаа дууслаа. Багшилж болохгүй гэв. Яагаад? Ард иргэдийн олон хүүхдэд сүрьеэ халдаана. Гэхдээ ажилтай болсон. Эхлээд эвлэлийн хороонд зааварлагч. Удсан ч үгүй



амьдралын турш ажиллаж яваа хэвлэл мэдээллийн газар орж сэтгэлийн гуниг сарниж эхэлсэн. Эм тариа үргэлжилсээр л. Нийгмийн халдварт өвчтэй надад өвөр нээж ханьсах эмэгтэй таарахгүй биз хэмээх санаашрал бодолд уяатай. Эмнэлгийн хүн өвчтнийг энэрэх сэтгэлтэй байдаг

болохоор хагацал зовлонд хат суусан Жанчив маань тохойн чинээ үрээ тэвэрсээр насаараа ханьсахаар хүрээд ирдэг байна. Дөчин жил болжээ. Ашгүй, сүрьеэ халдсангүй. Хөөе, эмээ уухаа мартаагүй биз гэнэ. Хааяа эмийг маань тоолно. За, чи айргийн сувилалд эмчлүүлээд ир гээд эмчтэй ярьчихсан байна. Ингэж надад санаа тавьж байхад би эмчилгээгээ эрчимтэй хийлгэлгүй яахав. Уух эмээ улирал бүр очиж авна. Аймгийн сүрьеэ диспансерийн Жаргалантын аман дахь сувилалд бараг зун бүр явлаа. Уушигны өвчинд сайн гэсэн бүхнийг хэрэглэсэн дээ. Гурван жил гаруйн дараа хяналтнаас гарлаа. Эдгэрчээ гэсэн хэрэг. Гэхдээ биеэ чагнасаар. Хүйтний эрч чангарч ханиад нэмэгдээд ирэх үеэр ханиалгах хандлага илэрвэл хурдхан л сүрьеэгийнхэн дээр очно. Дахичихаж магадгүй, ганц нэг сар эм уух уу хэмээн гуйна. 1970 онд оношлуулснаас хойш хэдэн жил өнгөрчिव? Сүрьеэгийн орон дээр нэг ч удаа очиж хэвтсэнгүй. Эмчилгээгээ эрчимтэй, тасралтгүй хийлгэ гэсэн эмчийн үг үнэн юм байна.

### ***Зөвлөх үг минь***

Ингэж би сүрьеэгүй болсон хүн дээ. Одоо ч энэ өвчний шаналал зовиурыг мартаа шив. Хэн ч хэлсэн юм бүү мэд. “Жор мэдэхгүй маарамбаас зовлон үзсэн чавганц дээр” гэдэг. Зовлон үзсэн тэр чавганц ингэж хэлнэ. Хоёр, гурван долоо хоног ханиалгавал нэг л биш шүү. Эмчид үзүүл. Оройтно шүү. Хоолны дуршил ямар байгаа? Орой тийшээ халуурвал сүрьеэ байж магадгүй дээ. Шөнө орон дотроо хөлрөх чинь хучлага ихэдсэнийх биш байх шүү. Цустай юм уу, цэртэйгээр ханиалгавал шинжлүүлсэн нь дээр гээд л ярина. Бас яаж халдвар авдгийг хэлээд өгнө. Ээ, агаар дуслуар халдана шүү гэх байх. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, танай ах сүрьеэтэй бол ярих, найтаах, ханиахад нь нөгөө нян гэдэг “дайсан” агаарт цацагдана. Тэгээд л чи, танай гэрийнхэн, хамт байсан хүмүүс халдвар авна.

## СҮРЬЕЭГҮЙ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА



Түүнээс гадна сүрьеэгээс урьдчилан сэргийлэх талаар зовлон үзсэн чавганцаас асуувал мэдээж хурц үедээ байгаа сүрьеэтэй хүнтэй болж өгвөл ойр дотно байхгүй бай. Орон гэрийнхээ агаарыг цэвэр байлга гэнэдээ. Биеийн дархлаагаа сайн байлгахын тулд тэжээллэг, чанартай хоол ид, гэр орон, ажлын нөхцөлөө сайн байлга, агаар салхинд яв, биеийн хөдөлгөөн чухал шүү гээд л зөвлөнө. Бас БЦЖ вакцин хийлгээрэй гэж захиана. Энэ бол хүүхдийг дөнгөж мэндэлмэгц 24 цагийн дотор буюу хоногт нь багтаан хийлгэх тариа юм. Түүнийг хийлгэснээр хүүхдийн бие гаднаас орох вирусыг эсэргүүцэн “нам дарах” чадвартай болно. Насан турш сүрьеэгээр өвчлөхгүй болчихно.

Би нэмээд ганц нэг зүйл зөвлөхөд хүний ямар ч эд эрхтэн өвчилдөг гэх юм билээ. Үүнийг ойлгуулах гэсэн хэрэг юм уу даа, хүний биеийн үс, хумснаас бусад нь өвчилнө гэдэг. Тархины сүрьеэ гэхэд менингит болж хүндэрнэ. Зонхилох нь уушигны сүрьеэ. Мөн аль ч насны, ямар ч хүн өвчилнө. Амьдрал дорой айлынхан өвчилдөг гэх яриа байдаг л даа. Энэ бол “сүрьеэ ядуу хүний өвчин” гэсэн үг биш. Мөнгө төгрөгний хүрэлцээ муугаас амт чанаргүй, тэжээллэг муутай хоол хүнс хэрэглэж орон гэр хүйтэн, хувцас хунар муу байснаас тиймэрхүү айлынхны хүмүүсийн биеийн эсэргүүцэл нь доройтож амархан халдвар авна гэсэн хэрэг.

***Уламжлах хүсэлт минь***

“Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа”. Энэ зорилгод хүрэхэд иргэд сайтар урьдчилан сэргийлэх, тууштай, төгс эмчлүүлэх, эмч мэргэжилтнүүд газар авахуулалгүй зөв оношлон эмчилгээний горимыг чанд баримтлахаас гадна төр засгийн бодлого, дэмжлэг хэрэгтэй. Энэ талаар гаргасан дэд хөтөлбөр, чиглэл бий ч гэсэн түүнийг бүрэн төгс үр өгөөжтэй хэрэгжүүлэх ажлыг чанаржуулмаар байна гэдгийг тэдгээр бодлого чиглэлийг хэрэгжүүлэлтийг зохион байгуулдаг, үр дүнг тооцдог хүмүүст сануулмаар бодогддог.

Сүрьеэгээс сэргийлэх, эмчлэх асуудал хариуцсан хүмүүсийн сэтгэл дундуур явдаг ганц нэг үгийг сонссоноо эрэгцүүлж бодох үе гардаг. Тухайлбал, сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийг зөвхөн өөрсдийг нь төдийгүй гэр бүлийнхнийг хяналтад авдаг журам тогтоогоосой гэдэг юм билээ. Эмнэлгийнхэн өөрсдөө энэ ажлыг зохион байгуулах гэхээр бензен шатахуун, томилолтын зардалд “чөдөрлөгдчихдөг”. Тэгэж хяналтад аваагүй, урьдчилан сэргийлэх дадал хэвшүүлээгүйгээс эхнэр нөхөр, ээж аав, ах дүү, үр хүүхдийнх нь тээж явсан нөгөө халдвар гурав, дөрвөн жилийн дараа идэвхжин өвчилдөг байна. Мөн сүрьеэг хариуцсан орон тооны ажилтан бий болгож түүнтэй хатуухан хариуцлага тооцдог байвал нэг байтугай алхам урагш ахина гэлцдэг. Түүнээс гадна амьдралын боломж муутай айл өрхөд илчлэг сайтай хоол хүнсний дэмжлэг үзүүлэх талаар төсөвт тусгах юм уу, төслийн шугамаар дорвитой арга хэмжээ авбал чухал байна. Төр засаг энэ мэт хэдхэн асуудлыг тууштай шийдвэрлээсэй. Сүрьеэ нийгмийн халдварт өвчин. Гэхдээ эдгэрнэ. Иргэн хүн ч, эрүүл мэндийнхэн ч хичээж, дээр нь улс аймгийн төр засаг дэмжлэг өгөх хэрэгтэй. Хамтдаа хичээе, тэмцье.

*“Монцамэ мэдээ” сонин 2011 он. №54*

**Танихгүй нян ирээдүйд аялсан нь**

*Ч.Болортуяа  
“Өдрийн шуудан” сонин*

Сүрьеэгийн нян “аялан аялсаар” 2050 онд очжээ. Өнөө дэлхийг “барьцаалж”, хамаг хөрөнгийг нь хуу залгидаг байсан сүрьеэгийн нян хүний оюун бодлоос бүрэн арчигдсан байх юм. Харин ганц нэг өвгөд, хөгшид 39 жилийн өмнөх гашуун түүхийг



санахтай үгүйтэй. Дэлхий даяар сүрьеэгийн микобактери гэх улаан өнгөтэй савханцрууд хаа сайгүй хэрэн хэсч олон сая хүнийг үхэлд хүргэдэг байв. Хаана ариун цэврийн дэглэм алдагдсан, хүний биеийн дархлаа сулрах төдийг андахгүй, аль нэг эрхтэнд нь бат гээч бэхлэгдэнэ. Амьсгалын замаар халдварладаг учир хэнийг ч ялгалгүй өвчлүүлж, орхино.

Халдвар авсан өвчтөн жилд 10-15 хүнд нян тарааж, тэдгээрийн 10 хувь нь өвчилдөг байсан. Өвлийн тэсгим хүйтэн хасах 40-70 хэмд ч амьдрах чадвартай учраас ил задгай хаясан нус цэрээс хүнд халдварлуулдаг байж билээ. Дэлхий дээр жил бүр сүрьеэгийн есөн сая шинэ тохиолдол илэрч, 1.6 сая хүн нас бардаг байв. Энэ бүхнийг санан дурссан сүрьеэгийн нян орох газраа хайсаар. Яагаад ганц ч хүн намайг танихгүй байна хэмээн бодож халаглах зуур цагтаа “цалгиж” явснаа үргэлжлүүлэн бодох таатай байв.

Монгол Улсад жилд сүрьеэгийн 4213 шинэ тохиолдол илэрдэг байжээ. Тэдний олонхи нь ажилгүй иргэд тул нийгмийн дунд сүрьеэ өвчнөөр ядуу хүн өвчилдөг гэсэн ташаа ойлголт байж билээ. Тэгэхээр нь баян, нэр алдартай хүмүүсийг өвчлүүлж, амь насыг нь авч одох бүрийд олон хүн намайг ямар хүчтэй болохыг мэдсэн дээ. Хүмүүс нэг нарны доор адилхан агаараар амьсгалж байгаа тул хэн ч энэ өвчнөөр өвчлөх боломжтойг хожим ухаарсан нь харамсалтай. Намайг харанхуй, чийгтэй, бохир заваан орчинд дуртай гэдгийг мэдэхгүй халдвартай олон хүн тийм газар амьдардаг байж хөөрхий. Харин тэгтэл дэлхийн ямар эрдэмтэн гээч нь намайг нарны гэрэлд 2-7 цагийн дотор устдаг болохыг мэдсэн юм, халдвартай хүмүүсийг цэвэр агаарт амрааж, тэжээллэг хоол хүнсээр тэтгэн, эм тариа хэрэглэсээр өвчтэй хүмүүст буян үйлдэж, харин намайг мөхлийн ангал руу илгээж орхисон. Миний зорилго талаар болохын даваан дээр ХДХВ-ийн халдвартай хүмүүс сүрьеэгийн халдвараар өвчилсөн. Тэр үед дэлхий дээр ХДХВ ба сүрьеэгийн халдвартай 5-6 сая хүн амьдарч байсан санагдана. Нийт хүн амын 1/3 хувь сүрьеэгийн халдвар авчихсан байсан юм даг. Гэтэл хүмүүс халдвар авсан хүний биеийн эсэргүүцэл сайн бол намайг цаашид үржиж олшрохгүй унтаа байдалд орж хэдэн жил ч байж болдгийг мэдээд дархлаагаа маш сайн болгож билээ. Зарим нь ч хоол унд, ажил амралтаа зохицуулахгүй, сэтгэл санааны таагүй байдалд ороход тэр дор нь би сэргэж, өвчлүүлдэг байсан.

Хүн бүр сүрьеэгийн халдвар авах магадлалтай ч халдвар авсан болгон өвчлөхгүй гэдгийг мэдсэн нь шинжтэмдэг илэрсэн даруйд эмчид хандаж, эмээр бөмбөгдөж өгсөн дөө. Би аргагүйн эрхэнд амьдарч байсан гэрээ орхиод хөсөр хаягдсан юм. Хүмүүс ДОХ



болон ХДХВ-ийн халдвар ямар аюултайг мэддэг хэрнээ намайг төдийлөн тоодоггүй байсан цаг саяхан. Харин эмч нар ХДХВ-ийн халдвартай тохиолдолд сүрьеэгээр өвчлөх магадлал өндөр гэдгийг ойлгуулсан явдал хүн төрөлхтөнд ухаарал авчирсан юм.

Тэр үеэс эхлээд намайг нэг мөсөн устгахын тулд хэн хүнгүй эрчимтэй ажиллаж эхэлж. Эмэнд дасалтай сүрьеэ үүсгэхгүйг чухалчлан анхаарсан. Эмэнд дасалтай сүрьеэ удаан хугацааны дараа эдгэрдэг, нас баралтын гол шалтгаан болдгийг эмч, мэргэжилтнүүд андахгүй мэддэг болохоор өнөөдөр би ийм байдалд хүрчээ. Гэхдээ тэр үед сүрьеэ өвчний шинж тэмдэг юу болохыг тодруулбал, гурван долоо хоногоос дээш хугацаанд ханиах, цээжээр өвдөх, цустай цэр гарах, ядрах, турах, шөнө хөлрөх, халуурахыг мэддэггүй байсан юм. Тиймээс эмчид хандахгүй хугацаа их алдана. Харин өвчнөө эрт оношлуулбал сүрьеэгийн багц эмийг хэрэглэн эдгэрдэг гэдгийг цөөнгүй хүн мэддэг байсан. Хоёр жилийн хугацаанд маш олон тооны эм уудаг учраас өвчтөнөөс маш их тэвчээр шаарддаг байв. Зарим нь эмээ дутуу эсвэл буруу хэрэглээд эмэнд дасалтай сүрьеэ үүсгэж нас барсан даа.

Харин тэр үед дэлхий нийтээр халдварт өвчний эсрэг зогсож, 2050 он гэхэд сүрьеэгийн тархалтыг бууруулах төлөвлөгөө нь биеллээ олж буй нь энэ аж. Монгол Улс ч мөн адил сүрьеэгийн тохиолдлыг сая хүнд нэгээс бага болгох дэлхийн сүрьеэтэй тэмцэх стратегийн зорилтод хүрэхийн төлөө чармайн ажилласны хүчинд 2050 он гэхэд энэ өвчин бүр мөсөн үгүй болжээ. Ирээдүйд аялсан сүрьеэгийн нян орох газаргүй болсон учир арга буюу хүн амьдардаггүй ертөнц рүү зугтсан гэдэг.

*Хаана хэвлэгдсэн*

## **ЭМЧЛҮҮЛЭГЧ НАРЫН БҮТЭЭЛ:**

### **Шинэлэгээр сэтгэж сүрьеэтэй тэмцье**

*Б.Батзаяа*

Нар мандлаа... Нарны туяа юунаас ч үл хамааран бүхнийг гэрэлтүүлэн шинэхэн өдөр эхэлж буйг зарлана. Өглөө бүхэн цонхоор харахад хүмүүс ажилдаа, сургуульдаа явах гэж энд тэндгүй гүйлдэн сандарч тэвдэн яарна. Энэ бол эмнэлэгт хэвтээгүй эрүүл хүмүүсийн амьдрал. Харин эмнэлэгт хэвтэж буй бидний амьдралын хэмнэл тэднийхээс шал өөр. Асрагч эгч нар бүхнээс цэвэрхэн байна шүү гэсэн сэтгэл зүрхтэйгээр өдөр шөнөгүй эмнэлгийн бохир бүхнийг зүлгэнэ. Сувилагч нар эмчлүүлэгчтэйгээ илүү тулж харьцдаг болоод ч тэр үү бидний сэтгэлийн зовиур, зовлон шаналалыг ойлгодог гэж би боддог. Харин эмч нар эмчлүүлэгчдийнхээ дотоод сэтгэл бус тухайн өвчнөө л гаргуун мэддэг. Гэхдээ эмч нар эмчлүүлэгчээ хурдан эдгэрээд эрүүл болоосой гэж сэтгэл зовнин шаналан суудаг алтан гартай хүмүүс. Тэдний амьдралд гэнэтийн шийдвэр их тохиох бөгөөд тэдгээр шийдвэр нь хүний амь настай холбоотой байдаг нь үнэхээр хүнд мэргэжил. Гэхдээ хүнийг аварна гэдэг гайхамшиг.

Эмнэлэгт хэвтээд аль хэдийнээ 4 сарыг ардаа орхижээ. Энэхүү хугацаанд сэтгэлээр унах үе их байсан хэдий ч зовлон нэгт найзууд, ар гэрийнхэн, эмч сувилагч нарын намайг гэх тэр л сэтгэлийн дэмээр тэр бүхнийг даван туулсан. Өвчин хэлж ирдэггүй хийсч ирдэг болохоор өвчнөө би амжилтын оргилд хүрэхийн өмнөх нэгэн шалгуур мэтээр ойлгож, цаашдын гэрэлт ирээдүйгээ төсөөлсөөр хурдан эдгэрэх болно.

...ажилдаа, хичээлдээ дарагдан туйлдсан хүмүүс харьжамрахаа бодсоор яаравчлан алхална. Харин эмнэлэгт эмчлүүлэгчид хурдан эрүүл болох юмсан гэсэн нууцхан хүсэлтэйгээр хөнжлөө нөмрөн хэвтэнэ.

Баяр хөөр, уйтгар гуниг, гэнэтийн зүйлээр дүүрэн хорвоогийн нэгэн өдөр ийнхүү дуусаж байгаа хэдий ч бидний амьдрал үргэлжилсээр...

## Ялалт бидний гарт

*Б.Ариунтунгалаг*

Гадаа цас хайлж урин дулаан цаг ирж байгааг хараад сэтгэл минь маш ихээр догдолж байгаагаа мэдэрч байлаа. Гэтэл миний зүрх сэтгэлд үргэлж намайг айдас дагна. “Хэзээ энэ аймшгийн өвчнөөсөө салж, эрүүл саруул болж хотын гудамжаар тайван алхаж явах бол..?” гэж бодон эмнэлгийн шилэн цонхоор харж, бурхандаа залбирч сууна. Анх олон эмэнд дасалтай сүрьеэгээр өвдсөн гэж сонссон тэр л өдрөөс эхлэн хорвоо хөмрөх шиг болж билээ. Гэхдээ л би “Хэзээ ч шантарч болохгүй. Хайртай хүмүүсийнхээ төлөө, хамгаас хайртай хүүгийнхээ төлөө энэ аймшигт өвчинтэй тэмцэх ёстой.” гэсэн бодолтойгоор эмчилгээнд орохоор эмнэлэгт ирсэн юм. Эмчилгээ эхэлсэн эхний өдөр үнэхээр аймшигтай, маш олон төрлийн 12 ширхэгтэй хүчтэй эм ууж, хүчтэй тариа тариулсаны дараа удалгүй толгой минь эргэж, огиудас хүрч, нүүр хацар халуу дүүгэж, зүрх хүчтэй дэлслээд л үнэхээр хүнд байв. Эм тариа, орчиндоо дасах гэж эхний сар маш хэцүү санагдаж байв. Эмчилгээний явцад маш олон янзын гаж нөлөө гардаг гэж сонсож байсан болохоор тэсэх хэрэгтэй л гэж өөрөө өөртөө хэлдэг байв. Одоо харин эмчилгээ эхэлсэнээс хойш 3-н сар гаруй хугацаа өнгөрч дээ. Өдрөөс өдөрт бие минь сайжирч байгаа болохоор үнэхээр их баярлаж улам ч их эрч хүчтэй болж энэ их зовлон бэрхшээлийг даван туулах итгэлтэйгээр урагшаа тэмүүлж байна даа. Бидний зовлонг хамгийн ихээр ойлгож үргэлж сайхан урмын үгээ хайрладаг сүрьеэгийн клиникийн эмч, сувилагч, асрагч нартаа болон үнэ төлбөргүй эм тариагаар ханган байгаа улсынхаа төр засагт, глобаль сангийнхаа хамт олонд үнэхээр их баярласан талархсанаа илэрхийлье. Аймшигт өвчний эсрэг хамтдаа тэмцэцгээе.

Өглөө бүр мандаж байгаа нарыг харах сайхан шүү...

## Сэтгэлийн үг

*Д.Энхчимэг*

Намрын шаргал өдөр бие тааруу гүн бодолд дарагдан гэр орноо, үр хүүхдээ орхин олон сараар эмнэлэгт хэвтэхээр эмнэлгийн зүг зүглэлээ. Би чинь өөрөө хөгжлийн бэрхшээлтэй, бие даах чадвар дутмаг, эмчилгээ хүнд гэх мэтчилэн сэтгэл хөндүүрлэсэн асуудал

ар араасаа хөвөрсөөр л...

Тиймээ тэр нэг өдөр ямар сайхан, халуун дулаан тохилог орчинд чадварлаг хамт олон угтан авсан билээ. Эмч, сувилагч, асрагч нар бидэнд эелдэг зөөлөн хандан “Миний хүү, охин яав ийв яасан?” гэж урмын үгээр тэтгэх нь сайхан.

“Эмчилгээгээ бие сэтгэл, зориг тэвчээрээр даван туулж, би эдгэнэ” гэсэн бодлыг тээсээр...

Өдрөөс өдөрт эмчилгээндээ дасан зохицож бие маань сайжирсаар нэг л мэдэхэд 5 сарыг ардаа орхижээ. Цуг хэвтэн эмчлүүлсэн эмчлүүлэгчид маань яг л надад нэг л хамт олон шиг сэтгэл төрүүлдэг.

Тиймээ өнөөдрийг хүртэл надад тусалж дэмжсэн та бүхэндээ чин сэтгэлээсээ талархаж байна. Нэг өдөр шинээр эхэллээ. Хаврын нар ээж, сэтгэл сайхан байна.

Дөчин градусын хүйтэнд тэсвэртэй нянг  
Дөрвөн эмийн хүчээр дарна  
Дөрвөн эмтэй хүч хавсран  
Канамидин эм нам даралцлаа  
Гарын таван хуруу шиг хүчтэнд  
Гайхал нян нам дарагдлаа.

### Ялалт бидний гарт

*Д.Болор-Эрдэнэ*

Давхар давхар хамгаалалттай шилэн хаалганы цаана амьдрал үргэлжилсээр...

Эмнэлгийн саруулхан өрөөнд хүн бүр өөр өөрийн өвчинтэйгээ тэмцэлдэн дотроо шаналцгаана. Амьсгалын замын өвчин болохоор тархац хурдан, эдгэрэх хугацаа нь урт эмчилгээний явцад тэсвэр тэвчээр шаардсан хүнд бэрх үеүүд олон тохиолдож байлаа. Хөдлөх нь битгий хэл амьсгалж ч чадахгүй болтлоо өвчиндөө ядарч сульдсан бие итгэл найдваргүй харцаар цав цагаан тааз ширтэн хэвтэж байтал хаалга халаадаа намируулаад орж ирлээ. “Биеийн байдал хүнд байгаа шинжилгээний хариу болоод цээжний зурагтай чинь үзэж танилцсаан. Би итгэж байна айх зүйлгүй хамтдаа тэмцье. Хичээгээрэй” гэж итгэлтэй шийдэмгий дайчин харцаар харж хамгаалттай цагаан маскныхаа цаана нууцхан инээмсэглэл тодруулан гарч явлаа. Өдөр бүр ийм л дулаахан инээмсэглэл дайчин итгэл найдвартай харцнаас эрч хүч

авч өвчинтэйгээ тэмцсээр нэг л мэдэхэд 3 сарыг ардаа орхисон байлаа. Эмчилгээний явцад хүнд бэрх шантрах үе олон байсан ч би даван гарсан би одоо чөлөөтэй явж, хөдөлж амьсгалж байна. Энэ л бидний ялалт. Өдөр шөнөгүй жижүүрлэн бидний төлөө энэ аймшгийн өвчний эсрэг тэмцэж байгаа эмч, эмнэлгийн ажилтан, сувилагч, асрагч нартаа чин сэтгэлээсээ талархаж байна. Тиймээ үнэхээр ялалт бидний гарт эзэн хичээвэл заяа хичээнэ гэдэг шүү дээ.

## Шинээр сэтгэж сүрьеэтэй тэмцье

*П. Золзаяа*

“Каашаа аваарай” гэх нярвын дуу өглөө болсныг гэрчилнэ. Энэ 2 үгийг сонсон өглөөг угтсаар нэг л мэдэхэд хагас жилийг ардаа орхижээ. Хагас жил эмнэлэгт гэж бодохоор аймшигтай байгаа биз? Тиймээ аймшигтай санагдаж байна. Нөгөө талаар өвчнөө эмчлүүлж бие маань эдгэж байгаа гэж бодохоор бас ч тийм биш болохыг мэдэрч байна. Гэхдээ энэ 6 сар ямар ч бэрхшээлгүй урсгалаараа урсаж өнгөрсөнгүй. Өдөр болгон бие болоод сэтгэл санааны тэмцэл явагдаж байсан юм. Хамгийн хайртай хүмүүсээсээ тусгаарлагдаад, хийх дуртай зүйлээсээ татгалзаад, гэр орон, амьдрал ахуйгаа орхиод удаан хугацаагаар эмнэлэгт хэвтэнэ гэдэг бол хүнээс чамгүй тэсвэр, тэвчээр, сэтгэлийн тэнхээ шаарддаг болохыг л мэдэрч байна.

Эмнэлэгт энэ тасагт анх хэвтсэн өдрийг маш сайн санаж байна. Уриалгахан асрагч намайг дагуулан өрөөг маань зааж өгөөд ор дэр засаж тусласан нь яагаад ч юм сэтгэлд нэг л дулаахан санагдаж, өвчиндөө шаналсан надад бяцхан ч гэсэн сэтгэлийн дэм хайрласныг нуух юун. Тэгэхээр тэр л өдрөөс хойш сэтгэл санааны дэмжлэг багадахгүй юм байна гэдгийг ухаарсан гэхүүдээ. Мөн үүнээс гадна нөгөө талаасаа нэг тийм аймаар ч гэмээр юм уу, хатуу ширүүн ч гэмээр юм уу тэмцэлтэй тулгарна гэж төсөөлөөгүй байлаа. Ер нь сүрьеэ өвчний талаар ялангуяа эмэнд дасалтай сүрьеэгийн талаар төдийлөн ойлголт байхгүй байсантай холбоотойгоор эхлээд нилээд шоконд орсон. Дараа нь залгуулаад айдаст автаж эхэлсэндээ. Энэ эмчилгээг давж гарч чадах болов уу? Гэр бүлийнхэн маань зүгээр болов уу? гээд л... Ганцхан би ч ийм айдаст автаагүй байх гэж бодож байна. Тэгэхээр миний бодлоор сүрьеэ өвчин болон эмчилгээний талаарх мэдээлэл болоод энэ өвчнөөс яаж урьдчилан сэргийлэх

талаарх мэдээллийг хүмүүст нилээд сайн өгмөөр санагдсан. Миний санахад эхний ээлжинд өрхийн эмнэлэгүүдтэй, эсвэл сургуулийн эмч нартай хамтарч урьдчилан сэргийлэх үзлэгт хүүхдүүдийг ядаж жилд 1 удаа хамруулах ч юм уу? Харин насанд хүрэгсдийг албан байгууллагаар нь дамжуулан хамруулах ч юмуу. Энэ мэтээр урьдчилан сэргийлвэл энэхүү өвчний тархалт багасах мэт санагдана. Нөгөө талаас анхан шатны сүрьеэгийн диспансерыг чадвартай эмч, ажилтнуудаар бүрдүүлж чадвал аль аль талаасаа өвчлөл багасах байх гэж бодогдож байна. Гэхдээ энэ бол зөвхөн миний л бодол юм.

Мэдээж хэвтэж эмчлүүлж байх хугацаан дахь бэрхшээл болгоныг тоочвол нилээд цаас хэрэг болох бизээ. Ямартай ч гэсэн 6 сарын хугацаанд бэрхшээлгүй өнгөрсөн өдрийн тоо цөөхөн байсныг санаж байна. Халдвартай энэ өвчнөөр олон хүн битгий зовоосой л гэж хүсэх байна. “Нийгмийн халдварт” гэсэн тодотголтой болохоор хүмүүсээс, нийгмээс тусгаарлагдана гэдэг бол хамгийн том бэрхшээл юм гэдгийг яс махандаа тултал мэдэрч байна. Энэ л аймаар...

Гэхдээ бид үр хүүхдүүдийнхээ, хайртай хүмүүсийнхээ төлөө энэ өвчнийг газар авхуулахгүйн төлөө хамтдаа тэмцэж чадна. Тийм ээ бид уух эмтэй, хажуудаа эмч нартайгаа байгаа цагт заавал давж гарна. Өөрийнхөө бичсэн нийтлэлээр:

“Алтан наран биднийг адилхан гийгүүлдэг шиг

Амьдрал биднийг адилхан гийгүүлдэг шүү... гэж та бүхэндээ захиж байна.

### **Сүрьеэтэй тэмцэх өдөрт зориулав**

*Б.Мөнхбат*

Дэлхийн хэмжээнд тулгамдаж байгаа аюулт зүйлийн нэг бол яахын аргагүй сүрьеэ өвчин. Сүрьеэ өвчин нь нийгмийн амьсгалын замын халдварт өвчин гэдгийг хэн хүнгүй мэдэж байгаа. Ямар ч хүний хэлж ирдэггүй хийсч ирдэг аюулт зүйл бол өвчин зовлон билээ. Гэхдээ хүн жаргал даадаггүй зовлон даадаг яг үнэн үг. Анх олон эмэнд дасалтай сүрьеэгээр өвдөөд: “2 жилийн эмчилгээнд орно, 4-6 сарын хугацаанд эмнэлэгт хэвтэх эмчилгээний явцад янз бүрийн гаж нөлөө хүнд илэрдэг бүр түүнчлэн үхэхэд гомдолгүй гэсэн гэрээнд гарын үсэг зурах..”-аас эхлээд маш хүнд цохилтод орж байсан. Хэвтээд 2 сар болоход эм тариа болон байгаа орчин, цуг байгаа хүмүүстэйгээ дасан

зохицох гээд олон бэрхшээл байсан. Ар гэр, ажил төрөл гээд бүхий л зүйлээ орхиж олон сараар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхэд хүндрэлтэй байсан хэдий ч өвдсөн юм чинь давж гарахын тулд тэмцэх хэрэгтэй болсон. Сүрьеэгээр өвдсөн хүмүүс ихэвчлэн байнгын түгшүүртэй байдаг. Хамгийн гол нь сэтгэл санааны дарамттай байдаг. Эрүүл хүмүүс тэр бүр биднийг өвчинг ойлгохгүй. Харин олон эмэнд дасалтай сүрьеэгийн тасагт хэвтэж эмчлүүлж байгаа өвчтөнүүд маань бие биеэ ойлгож сэтгэл санааны дэм өгдөг. Үнэхээр харамсалтай байдаг аа. Би залуу хүн тул хийж бүтээх зүйл: эцэг эхээ асрах, гэр бүлтэй болох зэрэг хийх ажил их байдаг. Ямартай ч давж гарах хэрэгтэй. Намайг дэмжиж ирээдүйд минь итгэл найдвар өгч эмчилж байгаа олон эмэнд дасалтай сүрьеэгийн тасгийн эмч, сувилагч, асрагч нартаа чин сэтгэлээсээ баярлаж явдаг. Эмчилгээний явцад дотор муухайрах, ядарч сульдах, хоолонд муу болох, бүр эм тариандаа харшлах үе олон байсан хэдий ч хурдан эдгэрч үеийн олонтойгоо мөр зэрэгцэн өөрийн хүсэл мөрөөдлөө биелүүлж аз жаргалтай амьдрахын тулд тэмцэж байна. Энэ өвчний төлөө хамтдаа тэмцэж байгаа эмч нартаа болон эм тариагаар ханган нийлүүлж байгаа Глобаль сангийн бүх албан хаагчиддаа баярласан талархсанаа илэрхийлж байна.

